



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/515

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6"а", 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.6, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2.2, Төсвийн тухай хуулийн 14.2.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2.1.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны ээлжит 9 дүгээр хуралдааны 4 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/372 дугаар захирамжийн 4 дүгээр хэсэгт Цэрэг халалт, таталт, эмнэлгийн үзлэг явуулахад шаардагдах зардал 12,814,150 (Арван хоёр сая найман зуун арван дөрвөн мянга нэг зуун тавин) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир), нягтлан бодогч (Ц.Нармандах) нарт зөвшөөрсүгэй гэсэн хэсгийг Цэрэг халалт, таталт, эмнэлгийн үзлэг явуулахад шаардагдах зардлыг 12,814,150 (Арван хоёр сая найман зуун арван дөрвөн мянга нэг зуун тавин) төгрөгийг 10,772,650 (Арван сая долоон зуун далан хоёр мянга зургаан зуун тавин) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг аймгийн ЗДТГ-ын дарга (Х.Ган-Очир), нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Баярдалай) нарт, 2,041,500 (Хоёр сая дөчин нэгэн мянга таван зуун) төгрөгийг Засаг дарга данснаас гаргахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Ц.Нармандах)-д зөвшөөрсүгэй гэж өөрчилсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай

ДАРГА



Л.ГАНБОЛД